

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЭРДЭНЭ СУМЫН БИЧИЛ УУРХАЙГААР  
АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОХ ТУХАЙ ГЭРЭЭ

2019 он

№ 2019/01

Эрдэнэ сум

“Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын 2.4, 3.1.3, 6.1.3-т заасны дагуу нэг талаас Дорноговь аймаг (хот)-ийн Эрдэнэ сум, (дүүрэг)-ын Засаг дарга Э.Ганбаяр (цаашид “Засаг дарга” гэх), нөгөө талаас “*Ариун Уулын Эрдэнэ*” нөхөрлөл, хоршоо, бүртгэгдээгүй нөхөрлөл (цаашид “Бичил уурхай эрхлэгч этгээд” гэх)-ийг төлөөлж нөхөрлөлийн дарга (албан тушаал) *Ц. Тамбат* нар (цаашид хамтад нь “Талууд” гэх) дараах нөхцөлөөр харилцан тохиролцож 2019 оны 03 дугаар сарын 01-ны өдөр энэхүү гэрээг (цаашид “Гэрээ” гэх) Эрдэнэ сум (дүүрэг)-д байгуулав.

**Нэг. Ерөнхий зүйл**

1.1. Бичил уурхай эрхлэгч этгээд нь Эрдэнэ сумын Бүрдэнэ багийн (дүүрэг)-ийн Хунхат нэртэй газарт орших 5 гектар талбайд журмын 6.1.3-т заасны дагуу 2019 оны 12 дугаар сарын 31-нийг хүртэл нэг жилийн бичил уурхай (жоншны төрөл) олборлохтой холбогдсон үйл ажиллагааг эрхэлнэ.

1.2. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талаар сум (дүүрэг)-ын Засаг дарга, бичил уурхай эрхлэгч этгээдийн хооронд үүсэх харилцааг энэхүү гэрээгээр зохицуулна.

**Хоёр. Сум (дүүрэг)-ын Засаг даргын эрх, үүрэг**

2.1. Сум (дүүрэг)-ын Засаг дарга нь “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын 6 дугаар зүйлд зааснаас гадна дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.1. бичил уурхай эрхлэгч этгээдэд ногдох талбайн хэмжээг тогтоож, байршлын зургийг гэрээнд хавсаргах;

2.1.2. хог хаягдлын цэгийн байршлыг тогтоож, сагандартын дагуу савтай болох.

2.1.3. бичил уурхай эрхлэгч этгээдийн олборлосон ашигт малтмалыг ангилан ялгах, баяжуулах талбайг тогтоох;

2.1.4. бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу нөхөн сэргээлтийн зардлыг тооцож, бичил уурхай эрхлэгч этгээдтэй тохиролцсоны үндсэн дээр зохих хөрөнгийг төвлөрүүлэх;

2.1.5. бичил уурхайн ажилтнуудад (цаашид “ажилтан” гэх) зориулсан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалтыг мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар зохион байгуулах;

2.1.6. Журмын 2.2.2-т заасаны дагуу тухайн аймаг, нийслэлд оршин суугчаар бүртгүүлсэн иргэнийг тухайн талбайд ажиллуулахад хяналт тавих.

2.1.7. энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг бичил уурхай эрхлэгч этгээдээс шаардах;

2.1.8. байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт тавих;

2.1.9. хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа үйл ажиллагааг зогсоох.

2.1.10 Бичил уурхай эрхлэгчид Байгаль орчны нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг ажлын 5 хоногт багтаан батлуулж барьцаа хөрөнгийг байгаль хамгаалах санд төвлөрүүлэх.

### **Гурав. Бичил уурхай эрхлэгч этгээдийн эрх, үүрэг**

3.1. Бичил уурхай эрхлэгч этгээд дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1. бичил уурхай эрхлэгч этгээдэд олгосон талбайд ашигт малтмал олборлох үйл ажиллагаагаа явуулах;

3.1.2. ажилтнуудыг тогтоосон талбайд суурьшуулах;

3.1.3. суурьшлын талбайг тохижуулж, ахуйн болон үйлдвэрийн хог, хаягдлын цэгийг байгуулах;

---

3.1.4. гэрээгээр олгосон талбайд нөхөрлөл, хоршоо, бүртгэгдээгүй нөхөрлөлийн гишүүн бус этгээдийг ажиллуулахгүй байх;

3.1.5. байгаль орчныг хамгаалж, гол, горхи, булаг шанд, уст цэгийг бохирдуулахгүй байх;

3.1.6. бичил уурхайн аюулгүй байдлын дүрмийг дагаж мөрдөх. болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

3.1.7. хууль тогтоомж, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны болон нөхөн сэргээлтийн чиглэлээр ажилтнуудад сургалт, сурталчилгаанд бичил уурхайчдыг идэвхтэй оролцуулах;

6.1. Энэхүү гэрээ нь 20/19 оны 03 сарын 01 өдрөөс . . . 20/19 оны 12 сарын 31 өдөр хүртэл хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

6.2. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлосон талбайд нөхөн сэргээлт хийж орон нутагт хүлээлгэж өгснөөр энэхүү гэрээний үүрэг дуусгавар болно.

6.3. Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж талууд тус бүр нэг хувийг хадгална.


**Долоо. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах**

7.1. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ.

7.2. Энэхүү гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь түүний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд гэрээний салшгүй хэсэг болно.

**Гэрээ байгуулсан:**

Дорноговь аймаг	(хот)-ийн.	Эрдэнэ	сум
(дүүрэг)-ын Засаг дарга			
/...../ /Э.Ганбаяр /			
/эцэг/эх/-ийн	нэр,	нэр,	гарын үсэг,
тамга, тэмдэг/	"....." (нөхөрлөл, хоршоо)		төлөөлж
/эцэг/эх/-ийн	нэр,	нэр,	гарын үсэг,
тамга, тэмдэг/			



**Сунгалт:**

Дорноговь аймаг	(хот)-ийн.	Эрдэнэ	сум
(дүүрэг)-ын Засаг дарга			
/...../ /Э.Ганбаяр /			
	20.... оны .....сарын ..... өдөр		
/эцэг/эх/-ийн	нэр,	нэр,	гарын үсэг,
тамга, тэмдэг/	"....." (нөхөрлөл, хоршоо)		төлөөлж
/эцэг/эх/-ийн	нэр,	нэр,	гарын үсэг,
тамга, тэмдэг/			
	20.... оны .....сарын ..... өдөр		

Хунхатын 2019.03.01

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Бүрдэнэ багийн Хунхатын зургаг  
Бүрдэнэ сумын газрын байршил зургаг олгосон газрын байршил зургаг  
ууланд бичиг уурхайн зориулалтаар


№ 2

"Аргалын уулын эрдэнэс" нөхөрлөл

Талбай 5 га

X=505835.3384 Y=4880709.0731  
X=505425.1983 Y=4880817.4947  
X=505496.5246 Y=4880926.8647  
X=505896.4630 Y=4880809.7103

№ 1



Д.Жаргалсайхан

Наран эгтэ

Зургаг үйлдсэн: Газрын даамал